# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 30 өдөр Дугаар А/212. Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 20 дугаар цэцэрлэгийн
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын А/126 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 4 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 1,772,786.6 (нэг сая долоон зуун далан хоёр мянга долоон зуун наян хоёр төгрөг жаран мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн 20 дугаар цэцэрлэг (Д.Мөнхзаяа)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 1 нэр төрлийн 1,772,786.6 (нэг сая долоон зуун далан хоёр мянга долоон зуун наян зургаан төгрөг жаран мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгахыг Баянзүрх дүүргийн 20 дугаар цэцэрлэг (Д.Мөнхзаяа)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА В.ОЮУМАА

1425010636

ᠰᠠᠶᠢᠳ

Б. Оюмаа

ᠪ᠂ ᠣᠶᠤᠮᠠ

1425030539



Нийслэлийн өмчийн харилцааны газрын
даргын 2025 оны 06..... дугаар сарын 10........-ны
өдрийн А/117-дугаар тушаалын хавсралт

# Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 20 дугаар цэцэрлэг

| № | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | хэмжих нэгж | тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Эвдрэл гэмтэл | ӨХБЗ-ийн дүгнэлт | Байгууллагын үнийн санал | НӨХГ мэргэжилтний үнийн санал | ЭБХХХК-ын хурлын шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ном сэтгүүл | 10 | ш | 195 | | 1,772,786.6 | 1,772,786.6 | - | ашиглалтгүй | актлах | устгах | устгах | устгах |
| | Нийт данснаас хасах хөрөнгийн дүн | | | | | 1,772,786.6 | | | | | | | |
| | Үнээс Худалдах хөрөнгө | | | | | | | | | | | | |
| | Актлах хөрөнгө | | | | | 1,772,786.6 | | | | | | | |
| | Татан төвлөрүүлэх хөрөнгө | | | | | | | | | | | | |